



**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/302

Улаанбаатар хот

**Шалгалтын комисс томилох,  
удирдамж батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 9, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, мөн хуулийн 9.6.1, 9.6.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн Батлан хамгаалах яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2023 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалах яамны гүйцэтгэх албан тушаал болон яамны харьяа ТӨААТҮГ-ын дарга (захирал)-ын албан тушаалд шинээр томилогдох алба хаагчдаас ерөнхий шалгалт авах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шалгалтын удирдамжийг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Шалгалтыг холбогдох хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар тогтоосон шаардлага, шалгуур үзүүлэлтийг чанд баримтлан тухай бүр зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч байхыг шалгалтын комиссын дарга (хурандаа Р.Энхболд)-д хариуцуулсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж)-т даалгасугай.

ДАРГА  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Д.ГАНХУЯГ

1323706691

Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны  
... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ АВАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Ерөнхий шалгалтын комиссын дарга:

Яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;

Гишүүд:

- Яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Батлан хамгаалах бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

- Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний байгуулалтын үнэлгээ хариуцсан шинжээч;

- Яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн Хууль, тогтоомжийн нийцэл, эрх зүйн актын уялдаа холбоог хангах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн.

Нарийн бичгийн дарга:

Яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны  
04 дугаар сарын 25-ны өдрийн  
А/Бд... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл:

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт, мөн хуулийн 22, 33 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Төрийн албаны зөвлөлийн Батлан хамгаалах яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны 05 дугаар хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлж Батлан хамгаалах яамны гүйцэтгэх албан тушаалд анх томилогдох алба хаагчаас ерөнхий шалгалт авч, үнэлгээ хийнэ.

Хоёр. Зорилго:

Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого болон холбогдох хууль тогтоомж, Засгийн газраас дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэргэжлийн өндөр чадвар, мэргэшил, ур чадвартай боловсон хүчнээр нөхөн хангахад оршино.

Гурав. Ерөнхий шалгалт явуулах ажлын үндсэн чиглэл:

Шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасны дагуу дараах чиглэлээр явуулна. Үүнд:

- 3.1. Ерөнхий мэдлэг (цэргийн хэргийн болон бусад);
- 3.2. Хууль эрх зүйн мэдлэг (Батлан хамгаалах салбарын голлох хуулиуд);
- 3.3. Монгол хэл, бичгийн чадвар;
- 3.4. Дүн шинжилгээ хийх чадвар;
- 3.5. Харилцан ярилцлага, багаар ажиллах болон шийдвэр гаргах чадвар.

Дөрөв. Бусад:

Шалгалт явуулах хугацаа, үнэлэх арга, дүнгийн хүснэгт, хүлээлгэх хариуцлага болон бусад асуудлыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу шийдвэрлэнэ.

Тав. Үр дүнг тайлагнах

Сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан болон тэнцсэн алба хаагчийн мэдээллийг комиссын дарга нь яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Батлан хамгаалах яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргад танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулна.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ